

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг : УДИРТГАЛ

1.1.Ерөнхий мэдээлэл

Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн хөгжлийн дунд хугацааны Стратегид байгууллагын Эрхэм зорилго нь:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эмч мэргэжилтний ур чадварын хөгжлийг дэмжиж, хүн амд ээлтэй, тэгш, чанартай тусламж үйлчилгээг хүргэхэд оршино гэж заасан байдаг. Үүний хүрээнд эмч, мэргэжилтнүүд, хүний нөөцийг хөгжүүлэх асуудал байгууллагын удирдлага, зохион байгууллалтын чухал бодлого болон хөгжсөөр байна.

2.2.Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

I.ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ТАРХВАР ЗҮЙН ХАНДЛАГА, ТӨСӨӨЛӨЛ

1.1.Хүн ам зүйн өөрчлөлт ба хүн амын хэрэгцээнд нөлөөлөх нь

- Хүн амын өсөлтийн 5 жилийн үзүүлэлт



Дархан-Уул аймгийн нийт хүн ам 2015 оноос 2020 онд 4323–өөр өссөн ба жилийн дундаж өсөлт 1519 байна.

- **Нас хүйсны бүтэц**

Насны бүлэг	2016	2017	2018	2019	2020
0-4	11,769	11,889	12,350	11,850	11,925
5-9	10,130	10,738	11,280	11,402	11,393
10-14	6,835	7,238	7,940	8,748	8,728
15-19	7,622	7,487	7,191	6,555	6,546
20-24	8,100	7,763	7,788	7,151	7,122
25-29	9,535	9,710	9,269	8,337	8,331
30-34	7,986	8,194	8,654	8,562	8,529

Насны бүлэг	2016	2017	2018	2019	2020
35-39	7,533	7,607	7,575	7,351	7,316
40-44	7,099	7,239	7,174	6,980	6,959
45-49	6,251	6,250	6,438	6,328	6,314
50-54	5,812	5,897	5,874	5,793	5,764
55-59	4,238	4,560	4,922	4,969	4,975
60-64	2,599	2,844	3,102	3,386	3,372
65-69	1,683	1,719	1,884	1,962	1,954
70+	2,604	2,744	2,797	2,797	1,215

Насны бүтцийг харахад 2016 онтой харьцуулахад 0-14 насны хүүхдүүд 125-1956-аар өссөн байна. Харин хөдөлмөрийн насны 20-29 насны залуусын тоо 1007-1296-аар буурч, 30-49 насанд 35-111-ээр нэмэгдсэн, 50-аас дээш ахмад насныхан харьцангуй тогтвортой ба 248-1029-аар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь идэр насны залуучуудын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байж болох ба ахмад настнуудын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүн ам хүйсны бүтэцээр

Хүйс	2016	2017	2018	2019	2020
Нийт дүн	102,413	101,879	103,726	102,014	102,014
Эрэгтэй	50,336	49,915	50,918	50,125	50,125
Эмэгтэй	52,077	51,964	52,808	51,889	51,889

➤ Дундаж наслалт

Он	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
2016	68.74	64.48	74.36
2017	68.67	64.37	74.35
2018	68.74	64.37	74.59
2019	68.84	64.43	74.73
2020	68.84	64.43	74.73

Хүн амын нийт дундаж наслалт 2016 оноос 2019 онд 0.10-аар нэмэгдсэн бол эрэгтэй дундаж наслалт 0.05-оор буурч, эмэгтэй дундаж наслалт 0.37-аар өссөн үзүүлэлттэй байна.

➤ **Хүн амын шилжилт хөдөлгөөн, хүн амын нягтрал**

Он	Шилжиж явсан	Шилжиж ирсэн	Хүн амын нягтрал
2015	3677	2306	30.6
2016	3147	2257	30.9
2017	1931	2533	31.5
2018	2702	2915	32.1
2019	2120	1978	32.4

Хүн амын шилжилт 2015 оноос 1557-оор, шилжиж ирэлт 328-аар буурсан ба хүн амын нягтрал жилээс жилд 0.3-0.6-аар нэмэгдсэн байна. Хүн амын нягтрал 2015 онтой харьцуулахад 1.8-аар нэмэгджээ.

➤ **Хүн ам зүйн ачаалал**

Насны төрөл	2015	2016	2017	2018	2019
Нийт	49.2	49.5	50.8	53.3	61.7
Хүүхэд	42.9	43	44.2	46.4	55.6
Хөгшид	6.3	6.4	6.6	6.9	6

Хүн ам зүйн ачаалал 2015 онтой харьцуулахад 12.5-аар өссөн ба хүүхэд 12.7-өөр нэмэгдэж, харин хөгшид 0.3-аар буурсан байна.

➤ **Нийгэм эдийн засгийн байдал**

А.Дархан-Уул аймгийн өрхийн тоо

Сум	2015	2016	2017	2018	2019
Нийт	29971	30097	30133	30503	28797
Дархан	25216	25314	25411	25767	24305
Орхон	977	974	987	1000	941
Хонгор	1584	1615	1608	1605	1535
Шарын гол	2194	2194	2127	2101	2016

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10000 хүн амд

№	Тэргүүлэх өвчлөл	2016	2017	2018	2019	2020
1	Амьсгалын тогтолцооны өвчин	1813.47	2165.96	1764.15	2717.55	893.5
2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1119.44	1615.27	1497.80	1305.49	794.4

3	Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин	703.69	708.66	681.75	712.91	178.9
4	Зүрх судасны тогтолцооны өвчин	1155.53	1116.75	1580.28	1247.02	311.0
5	Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	316.44	327.85	321.81	298.08	149.1

Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин өсөх хандлагатай ба 2016 онтой харьцуулахад 919.9 промилоор урьд оноос 1824.0 промилоор буурсан байна. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин 325-511 промилоор буурч байна. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин 2016 онтой харьцуулахад 524,7 промилоор буурсан боловч урьд оноос 534 промилоор буурч. Зүрх судасны тогтолцооны өвчин 2016 оноос 844,5 промилоор, урьд оноос 936 промилоор буурсан үзүүлэлттэй байгаа боловч 2016-2018 онуудад өссөн хандлагатай байна. Харин гэмтэл хордлого, гадны шалтгаант эмгэг жилээс жилд буурч байна.

Стационарт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөл 10000 хүн амд

№	Өвчлөл	2016	2017	2018	2019	2020
1	Нийт өвчлөл	3010.9	2976.8	3018.8	2975.7	2706.7
2	Халдварт ба шимэгч зарим өвчин	135.79	92.2	88.7	101.4	59.4
	үүнээс сүрьеэ	22.36	27.6	24.1	23.7	19.2
3	Хавдар	34.12	35.0	35.6	34.9	28.6
	үүнээс элэгний	7.79	7.8	9.9	11.7	8.5
	ходоодны	6.71	5.7	4.2	3.1	3.1
	улаан хоолой	0.59	0.5	1.5	0.7	0.4
	уушиг	0.99	2.4	4.4	1.5	2.1
	умайн хүзүү	3.16	3.2	1.6	2.5	1.2
	хөхний	1.28	1.4	1.1	1.6	1.3
4	Дотоод шүүрэл тэжээлийн бодисын солилцооны өвчин	125.53	125.53	145.2	137.8	60.0
	үүнээс чихрийн шижин	52.67	76.42	71.3	90.6	49.3
5	Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг	91.59	83.52	85.7	80.9	55.6
6	Мэдрэлийн тогтолцооны өвчин	118.48	125.73	165.2	184.4	220.7
7	Нүд дайврын өвчин	6.17	13.31	12.8	9.6	6.9
8	Чих хамар хоолойн өвчин	33.55	42.01	40.3	41.1	42.8

9	Зүрх судасны тогтолцооны өвчин	530.65	492.8	522.9	489.4	385.2
	үүнээс цочмог архаг хэрлэг	29.67	22.9	23.1	24.5	17.8
	цусны даралт ихдэх	203.30	174.2	235.1	247.6	138.2
	зүрхний ишеми	92.79	111.8	101.5	78.9	60.2
	тархинд цус харвалт	16.93	20.7	19.8	11.1	8.9
10	Амьсгалын тогтолцооны өвчин	431.79	551.0	464.1	498.6	323.1
	үүнээс томуу	2.69	14.1	4.4	1.7	42.4
	хатгаа	261.84	358.0	249.6	298.9	134.7
11	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	325.96	307.0	302.8	287.3	319.1
12	Арьсны өвчин	92.29	101.6	113.4	110.7	97.6
13	Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин	329.04	349.9	350.7	359.1	391.8
	үүнээс бөөрний сувганцар	202.01	81.3	209.2	221.9	271.5
	жирэмсний төрөлт төрсний дараах	366.08	337.4	330.7	354.2	325.6
14	Гэмтэл хордлого гадны галтгаант	120.57	117.6	131.5	120.1	106.4

Хүний нөөцийн хүртээмжийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
1	10000 хүн амд ногдох их эмчийн тоо	28.0	27.2	26.4	27.3	29.9
2	Нэг эмчид ногдох хүний тоо	357.1	368.0	380.3	365.7	333.3
3	10000 хүн амд ногдох сувилагчийн тоо	36.6	35.6	35.5	43.0	42.4
4	Их эмч сувилагчийн харьцаа	1.3	1.3	1.4	1.6	1.6

Эдгээр үзүүлэлтүүд нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох, эмч мэргэжилтнүүд, хүний нөөцийг чадавхжуулах, хөгжүүлэх, эмнэлгийн тусламжийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх шаардлагыг буй болгосон.

1.2.Бодлогын орчин

1.2.1. Эрүүл мэндийн талаар төрөөс баримталж буй бодлого

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх “Эрүүл Дарханчууд” дэд хөтөлбөр

- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Дархан-Уул аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Хөгжлийн стратеги төлөвлөгөөг Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”,
- Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Эрүүл Мэндийн Газрын 2021-2024 оны хөгжлийн стратеги төлөвлөгөө
- Нэгдсэн эмнэлгийн 2021-2024 оны хөгжлийн стратеги төлөвлөгөө
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Үүний эрүүл мэндийн хөгжлийн бодлогод:

- Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтыг олон улсын жишигт хүргэх
- Тэдний цалин урамшуулалын тогтолцоог боловсронгуй болгох
- Үйлчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх
- Хүний нөөцийн хуваарилалтыг зохистой болгох асуудлуудыг тусгасан байдаг.

1.2.2.ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн “Эрүүл мэндийн хүний нөөцийг хөгжүүлэх бодлого” –д Хүний нөөцийг хөгжүүлэх **чиглүүлэгч зарчмыг** тодорхойлсон.

- Анхан шатны тусламжид тулгуурласан, хоёрдогч, гуравдагч тусламжаар дэмжигдсэн, хүн амын хэрэгцээнд нийцсэн байх;
- Үр дүнтэй, боломжийн өртөгтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд хувь нэмрээ оруулах;
- Суурь чадвар, мэргэжлийн стандартуудыг баримтлах;
- Мянганы хөгжлийн зорилтуудтай уялдах;
- Эмзэг бүлгийн хүн амын хэрэгцээг гол болгох;
- Эрүүл мэндийн тусламжийг хөгжүүлэх үүргийг хүлээж, мэргэжлээрээ ахих дэмших бололцоог олгох;

1.2.3.Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хууль, эрх зүйн баримт бичгүүд

- Эрүүл мэндийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 25, 267, 2020 оны 151 дугаар тогтоолууд
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, нэмэлт өөрчилөлтөөр 395 тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 472 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл тогтоох тухай
- Эрүүл мэндийн Сайдын 2019 оны 406 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”
- Эрүүл мэндийн сайдын 2012-11-08-ны өдрийн 363 тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн ажиллагсдад шагнал олгоход мөрдөх журам”
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар “Албан тушаалын тодорхойлолт” үлгэрчилсэн загвар”

- Эрүүл мэндийн сайдын 2013 оны 68 дугаар тушаалар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”
- MNS: 5095:2017 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт

БОЛОВСРУУЛСАН ХНСХА